



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 1/574

Булган сум

“Айраг фестиваль” эвент зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.4, 23.1.9 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II хуралдааны аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай II/04 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөвт батлах тухай” XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Юнескогийн хүн төрөлхтний соёлын биет бус өвд Монгол Улсаа төлөөлөн бүртгэгдсэн хөхүүрийн айрагны соёлыг тээн авч ирж, түгээн дэлгэрүүлж буй малчид, адуучдыг хамруулан зохион байгуулагддаг “Айраг фестиваль” аялал жуулчлалын эвентийг зохион байгуулсугай.

2. Зохион байгуулалтад шаардагдах зардлыг хавсралтаар баталж Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах” төсөл арга хэмжээний зардлаас 168,825,512 (нэг зуун жаран найман сая найман зуун хорин таван мянга таван зуун арван хоёр) төгрөгийг зарцуулахыг сангийн нягтлан бодогч (Б.Бумцэнд), Орхон аймагтай хамтран ажиллах гэрээний дагуу нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн хөрөнгөөс 10,000,000 (арван сая) төгрөгийг зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. “Айраг фестиваль” эвентийг үр дүнтэй зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/3захирамж

6324010829

Аймгийн Засаг даргын 2024 оны 8 дугаар сарын 06-ны/ний өдрийн 057 дүгээр/дугаар захирамжийн хавсралт

Айраг-2024 наадмын тэмцээн уралдаан, зохион байгуулалтын зардал

Хэрэгжүүлэх арга хэмжээ		Шаардагдах төсөв /төгрөг/
Спортын тэмцээн уралдааны зардал		
1	Бөхийн барилдааны шагнал, зохион байгуулалтын зардал /32 бөх/	6,979,332
2	Сээр шалгах тэмцээний зардал	1,661,200
3	Шагайн харвааны шагнал, зохион байгуулалтын зардал	3,188,000
4	Шагайн наадгай тэмцээний шагнал, зохион байгуулалтын зардал	2,039,000
5	Шагайн нумт харвааны тэмцээний зардал	2,240,000
6	Хос морьтон тэмцээний зардал, зохион байгуулалтын зардал	1,614,800
7	"Айраг хэн сайн уух вэ" тэмцээний зардал	2,000,000
8	"Дэмбээ сайн уу" тэмцээний зардал	2,400,000
9	Сур харвааны тэмцээний зардал	6,475,880
10	Хамгийн сайхан айраг тэмцээний шагнал, зохион байгуулалтын зардал	2,400,480
11	Айрагны шилдэг хөхүүр тэмцээний шагнал	1,600,000
12	Дааганы уралдаан	3,186,240
13	Эмнэг сургах тэмцээн, зохион байгуулалтын зардал	877,800
14	Mobicom ажилчдын хоолны зардал	480,000
Нийт		37,142,732
Зохион байгуулалттай холбоотой зардал		
1	Хүндэт зочдыг хүлээж авах, тосох, байрлуулах зардал	14,621,800
2	Нээлт, хаалтын зардал	62,539,900
3	Шохой авах зардал	11,000,000
Нийт		88,161,700
Хэвлэл мэдээллийн зардал		
1	Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны зардал	10,960,600
Нийт		10,960,600
Иргэд олон нийтийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахад чиглэсэн зардал		
1	Цагдаагийн байгууллагын алба хаагчдын шатахуун, хоолны зардал	3,250,800
2	Онцгой байдлын газрын алба хаагчдын хоол, техник хэрэгсэлийн шатахуун	2,205,600
3	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, холбогдох зардал	1,043,640
4	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт хангуулах ажлын хэсгийн зардал	863,400
5	Хог хаягдал, орчны бохирдлыг зохицуулах ажлын хэсгийн зардал	1,787,040
6	"Булган мээж" ОНӨХХК ус зөөх машины зардал	1,686,000
7	Тохижилт үйлчилгээний ангийн зардал	11,293,920
8	Нийтлэг үйлчилгээний алба	16,030,640
9	"ЭБЦТС" ТӨХК	4,308,720
10	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын шатахууны зардал	90,720
Нийт		42,560,480
Дүн		178,825,512